



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/70

Хужирт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 49 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгаль хамгаалах санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын төвийн төвлөрсөн хогийн цэгийн гадна ил задгай асгасан хог хаягдлыг дотогш түрэх, дотор хог хаягдлыг цэгцэлж зам гаргах ажлын шатахууны зардалд 4000000 (дөрвөн сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардалд зарцуулагдах хөрөнгийг Байгаль хамгаалах сангаас зарцуулахыг Санхүүгийн албаны дарга (Д.Уранчимэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

250100139